



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3 - 4

- 1. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл* 3 - 4

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 22-ны өдөр
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 50 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ш.Раднаасэд;

Тасалсан: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Б.Жавхлан, Ч.Хүрэлбаатар.

Нэг. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 11 цаг 54 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 50 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Хавдисламын Баделхан гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн, Лхагвын Мөнхбат гишүүн, Салдангийн Одонтуяа гишүүн, Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг асуудал байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөл. Төсвийн тогтоолын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонгогч даргалагчийг сонгох тухай гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Төсвийн тогтоолын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах үүрэг бүхий

ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар тогтоолоор байгуулан ажилласан.

Нийт 14 оролцогч материалаа ирүүлснээс 7 оролцогчийг нэр дэвшүүлэхээр сонгон шалгаруулсан байгаа. Та бүхэнд ажлын хэсгийн санал, дүгнэлтийг танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг сонгож оруулах үүрэг бүхий ажлын хэсгийг бид өмнөх хуралдаанаар байгуулаад 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр миний бие ахалж ажилласан.

Ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр, 12 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд 3 удаа хуралдсан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн сонгон шалгаруулах зарыг хуулийн дагуу зохион байгуулж, нийт 14 иргэн оролцохоор цахимаар болон цаасаар материалаа ирүүлсэн.

Материалын шаардлагыг бүгд бүрэн хангасан гэж үзэж байгаа.

Хуулийн дагуу 14 оролцогчоос 13 оролцогч биечлэн ирж ярилцлагад оролцсон.

Нийт ярилцлагад оролцсон 13 оролцогчоос 7 гишүүнийг ажлын хэсэг сонгож оруулж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхээр сонгон шалгаруулаад байгаа.

Ажлын хэсгээс Тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхээр сонгон шалгаруулсан 7 оролцогчийг Та бүхэнд танилцуулж байна.

Нэгдүгээрт, Намжилдоржийн Энхбаяр, хоёрдугаарт Жамсрандоржийн Дэлгэрсайхан, гуравдугаарт Нинжбатын Ууганбаатар, дөрөвдүгээрт Амаржаргалын Энхбат, тавдугаарт Равсалын Рэнцэнбазар, зургадугаарт Лхагважавын Гангэрэл, долдугаарт Ланганы Отгонтуяа нарыг сонгон шалгарууллаа.

Нэр дэвшигчийн товч анкет болоод холбогдох мэдээллийг Та бүхэнд тараасан байгаа.

Ажлын хэсгээс нэр дэвшигчийг сонгон шалгаруулсан бөгөөд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье гэсэн энэ танилцуулгыг Та бүхэнд тараасан байна.

“Төсвийн тогтоолын зөвлөлийн гишүүн нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

60.0 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Энэ бол нэг талдаа эхний нэр дэвшигч нарын талаарх Байнгын хорооноос сонсгол явуулна. Тухайн нэр дэвшигч нараас асуулт асуух болоод тухайн ажил мэргэжилтэй холбоотой асуудлуудаар нь холбогдох асуудлуудаар сонсгол явуулж, сонсгол дээрээс тодорхой мэдээллүүд авах эрх нээлттэй гэж хэлэх байна.

Мөн сонсголын хүрээнд даргалагчийг сонгох тухай тогтоолыг бид баталлаа.

Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн миний бие Г.Тэмүүлэн өөрөө даргалахаар орж ирсэн байгаа гэдгийг эцэст нь хэлье.

Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүддээ баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 04 минут үргэлжилж, 11 цаг 54 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД